



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

Хуваарьт өөрчлөлт оруулах  
тухай

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн саналыг харгалзан Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалт болон Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийх тухай Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 287 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Сангийн сайдын 2014 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 123 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2014 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сар, улирлын хуваарь"-ийн Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хууль зүйн сайд, Хөдөлмөрийн сайдын багцын санхүүжилтийн сар, улирлын хуваарийг 1 дүгээр хавсралтаар, мөн тушаалын 9 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2014 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн сар, улирлын хуваарь"-ийг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

Хоёр. Санхүүжилтийг шинэчилсэн хуваарийн дагуу олгохыг Төрийн сангийн газар /Ч.Тавинжил/-т зөвшөөрсүгэй.

САЙД  Ч.УЛААН

000458